

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2013 ОНЫ 08 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Тайлант сард аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2 удаа хуралдаж 6 асуудал хэлэлцэж, 9 тогтоол баталлаа.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын дарга Х.Даваахүү аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд намрын ургац хураалтын бэлтгэл, 2013-2014 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар мэдээлэл хийлээ.

Мандал сумын Христийн шашны “Эзний улс”, “Мөнхийн шинэ чуулган” сүмийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг тус бүр 2 жилээр сунгах шийдвэр гаргалаа.

Тус аймгийн Ерөө сум байгуулагдсаны 90 жилийн ойг 2014 оны 7 дугаар сард тэмдэглэхээр тогтлоо.

Боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, газар тариалан, эрчим хүч, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт олон жил идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, өндөр амжилт гаргасан тус аймгийн харъяат 45 иргэнийг Монгол Улсын цол, одон медалиар шагнуулахаар шийдвэрлэж, Монгол Улсын ерөнхийлөгчид уламжиллалаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Тэргүүлэгчид 2013 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс Баруунбүрэн, Орхонтуул сумдад ажиллаж байна.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 92 жилийн ойн баяр наадмаар Монгол Улсын аварга цол хүртсэн Гунаажавын Эрхэмбаярт хүндэтгэл үзүүлэх “Сэлэнгэ түмний талархлын баяр, наадам”-ыг 2013 оны 8 дугаар сарын 2-ны өдөр зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс, ХААН банк, Төрийн банкны тус аймаг дахь салбаруудтай хамтран шууд харьцдаг төсөвт байгууллагуудын нягтлан бодогч, нярав нарт “Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журам”-ын дагуу төсөвт байгууллагууд бэлэн мөнгөний картын сүлжээнд орж байгаатай холбогдуулан сургалт зохион байгууллаа.

Дайчилгааны бэлтгэл нөөцийн 1-р зэргийн бэлтгэл үүрэгтний 10 хоногийн сургалтыг Дархан-Уул аймаг дахь Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн сургалтын төвд зохион байгуулж байна.

Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийдэд баригдаж буй нийтийн ариун цэврийн газрын барилгын ажлын явц байдалд аймгийн Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын хамтарсан ажлын хэсэг үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулж байна.

Тус аймгийн 2013-2015 $\hat{1} \hat{1} \hat{0} \hat{0} \hat{u} \hat{1} \hat{0} \hat{n} \hat{a} \hat{e} \hat{e} \hat{1} \hat{0} \hat{z} \hat{d} \hat{y} \hat{u} \hat{1} \hat{e} \hat{e} \hat{1} \hat{y} \hat{a} \hat{y} \hat{a} \hat{a} \hat{e} \hat{e} \hat{e} \hat{e} \hat{a}$ “Төсвийн тухай” хуулийн дагуу $\hat{0} \hat{e} \hat{e} \hat{e} \hat{N} \hat{a} \hat{i} \hat{a} \hat{e} \hat{e} \hat{1} \hat{y} \hat{a} \hat{i} \hat{a} \hat{i} \hat{a} \hat{0} \hat{y} \hat{1} \hat{0} \hat{0} \hat{e} \hat{l} \hat{a} \hat{a}$. Аймгийн төсвийн нийт орлогыг 2014 онд 11885743.0, суурь орлогыг 11693904.0 мянган төгрөгөөр санал хүргүүлснээс 2014 оны төсвийн нийт орлогыг 13145700.0 мянга, суурь орлогыг 12945191,0 мянган төгрөгөөр хяналаа. Үүнээс аймгийн төсвийн орлогыг 10541700.0 мянга, сумын төсвийн орлого 2604000.0 мянган төгрөгөөр тус тус хянагдлаа.

Сүхбаатар сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд тус сумын иргэдийн санал хүсэлтийг авч зураг төслийг “Арт-Сити” ХХК-иар ерөнхий төлөвлөгөөнд тусгуулан, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

Тайлант сард аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авах 70361111 утсанд нийт 14 өргөдөл, гомдол, ирж 7 өргөдлийг шийдвэрлэж, 7 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

07-р сарын 31-ний байдлаар

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн орлого	8806539.0	8085678.1	91.8
2	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	7205842.9	6173410.1	85.7
3	Орон нутгийн төсвийн зарлага	32082520.9	29497718.9	91.9
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлага	8511804.1	7084714.0	83.2
	Аймгийн ОНХСангийн зарцуулалт	1481524.0	547021.7	36.9
	Авто замын хөрөнгө оруулалт	109140.9	6600.0	6.0
4	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	1111416.4	230891.7	20.8
5	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	6607669.2	6607669.2	100.0
6	Засаг даргын нөөц	245491.9	313248.6	127.6

2013 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 91.8 хувь, улсаас авах санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 70.7 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 100.0 хувь тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 91.9 хувийн биелэлттэй, сумдын санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 127.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2012 оны 7-р сар	2013 оны 8-р сар
Нэг.Талх, гурил, будаа				
1	Гурил /1-гурил/	1 кг	850	800
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш	700-1500	700-1500
3	Нарийн боов	1 кг	1800-2300	1800-2300
4	Элсэн чихэр	1 кг	1800	1600
5	Цагаан будаа	1 кг	1800	2000
Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн				
6	Хонины мах	1 кг	7500	7300
7	Үхрийн мах	1 кг	9000	8500
8	Адууны мах	1 кг	7000	6000
9	Ямааны мах	1 кг	6500-6800	6500
10	Дотор мах цувдай	1 кг	4000	4000
11	Хиам, чанасан	1 кг	7500-9000	8500
12	Гахайн мах	1кг	7500	7000

Гурав.Сүүн бүтээгдэхүүн				
12	Сүү /задгай/	1л	700	600
13	Сүү /савласан/	1л	1700-1800	1700-1800
14	Тараг /задгай/	1л	900	700
15	Хорхой ааруул	1 кг	5000	5000
16	Айраг	1л	-	2500
17	Хуурай сүү /орос/	1 кг	4200	4200
18	Өндөг	ш	250-280	250
Дөрөв. Бүх төрлийн өөх тос				
19	Ургамлын тос	1 кг	2800-3000	2800-3000
20	Өөхөн тос	1 кг	1200	1200
21	Шар тос	1 кг	6200	8000
22	Масло /задгай/	1 кг	3600	3000
Тав.Хүнсний ногоо				
23	Төмс/Монгол/	1 кг	700	500
24	Лууван	1 кг	900-1000	600
25	Манжин	1 кг	1600	1500
26	Байцаа	1 кг	1600	600
27	Сонгино	1 кг	1800	1500
28	Өргөст хэмх /Монгол/	1 кг	-	1000
29	Тарвас /Монгол/	1 кг	-	1500
30	Өргөст хэмх /даршилсан/	ш	3000-4200	3000-4200
31	Алаг салат /даршилсан/	ш	2100-2500	2100-2500
Зургаа.Тээвэр шатахуун				
32	Бензин А-80	1 л	1540	1540
33	Бензин А-92	1 л	1650	1650
34	Дизель түлш	1 л	1780	1780

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1.Архивын талаар:

Төрийн архивын санд баяжилт хийх зорилгоор Зүүнбүрэн, Жавхлант, Сайхан, Ерөө сумын Засаг даргын Тамгын газар, Түнхэл тосгоны Захирагчийн алба, аймгийн Хүнс, хөдөө ах ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн газар, “Урсгал-Ус” ОНӨААТҮГазар, Ус, цаг уур, орчны шинжилгээний алба, Мэргэжлийн хяналтын газар, Сэлэнгийн долгио чуулга зэрэг газруудын баримтыг хүлээн авах ажлыг зохион байгуулж байна.

Тайлант сард Төрийн архивын баримтанд нягтлан шалгалт хийх ажлыг Нийтийн ахуй үйлчилгээний комбинатын 1964-1990 оны 132 хадгаламжийн нэгж, Цагаан толгойн сангийн аж ахуйн 1943-1990 оны 117 хадгаламжийн нэгж, Түнхэл тосгоны Мод бэлтгэлийн аж ахуйн 1960-1981 оны 69 хадгаламжийн нэгжид хийж хадгалах хугацаа дууссан, мэдээлэл, лавлагааны ач холбогдолгүй болсон, эрдэм-шинжилгээ, техник боловсруулалт хийх шаардлагатай, цахим хэлбэрт шилжүүлэх баримтуудыг олж илрүүлэх ажлыг хийлээ.

Архивын цаасан суурьтай баримтыг тоон хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Шаамар сумын тэжээлийн аж ахуйн 1968-1992 оны 8534 хуудас бүхий баримтанд мастер хувь үүсгэж, эрдэм-шинжилгээ техник боловсруулалтын ажил хийн

хадгалалтын түвшинг дээшлүүлэн, мастер хувиас Алтанбулаг сангийн аж ахуйн 1955-1964 оны 1760 хуудас баримтыг Photoshop програмд оруулж ашиглалтын хувь үүсгэлээ.

Байгууллага, иргэдэд архивын хуулбар 63, архивын баримт шилжиж ирээгүй тухай тодорхойлолт, холбогдох баримт олдоогүй тухай магадлагаа нийт 26 гаргаж өгч үйлчиллээ.

2.Гэмт хэрэг, зөрчлийн талаар:

Тус аймгийн Шүүхийн шинжилгээний албаны кримнаリティкийн шинжээч нар нь гэмт хэргийн газрын үзлэгт нийт 67 удаа мэргэжилтнээр оролцож, 112 ширхэг ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүллээ.

Мөрдөн байцаалтын туршилт болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд 18 удаа мэргэжилтнээр оролцож “Папилон” болон “Амьд сканер” станцаар гэмт хэрэгт холбогдсон, цагдан хоригдсон, захиргааны журмаар баривчлагдсан, эрүүлжүүлэгдсэн нийт 59 хүний гарын дардас хийж, мэдээллийн санд баяжилт хийлээ.

Шинжээч эмч нар нь хэргийн газрын үзлэгт нийт 28 удаа мэргэжилтнээр оролцож, алсын дуудлаганд 6 удаа явж, шүүх эмнэлэгийн магадлан шинжилгээ 15 удаа, гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 65 удаа тус тус хийлээ.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсролын чиглэлээр:

Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангаж шинээр барилга барихад цэцэрлэгүүд 3.2 тэрбум төгрөг, урсгал засварт 14.5 сая төгрөг, их засварт 625 сая төгрөг, гадаад орчны тохижилтод 1.9 сая төгрөг, ерөнхий боловсролын сургуулиуд урсгал засварт 59.6 сая, их засварт 261.4 сая, шинээр барилга барихад 1.2 тэрбум, гадаад орчны тохижилтод 44 сая төгрөг, нийтдээ цэцэрлэгүүд 4.3 тэрбум гаруй төгрөгийг, ерөнхий боловсролын сургуулиуд 1.6 тэрбум гаруй төгрөгийг зарцууллаа.

Сурагчдын дүрэмт хувцсыг нийлүүлэхтэй холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн захирал, үйлдвэрлэгч байгууллагуудтай 3 талт гэрээ хийж хэрэгжилтэнд хяналт тавин, хүүхдэд хүргэх ажлыг зохион байгуулж байна.

Хүүхдийн цэцэрлэгийн дутагдалтай багшийн судалгааг гарган, мэргэжлийн багшаар хангах ажлыг зохион байгуулж байна.

2.Эрүүл мэнд, биеийн тамирын чиглэлээр:

Аймгийн Эрүүл мэндийн газраас 2013 оны 8 дугаар сарын 9-ний өдөр Сүхбаатар өртөөнөөс Түнхэл өртөө хүртэлх галт тэрэгний аялал хийх хугацаанд 4 багийн 18 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд зорчигчдод “Ахмад настны эрүүл мэнд, Эрүүл зөв хооллолт, Гарын ариун цэвэр, Орчны бохирдолд-Эрүүл мэнд, Эхийн сүүний ач холбогдол, Хүүхдийн нэмэгдэл тэжээл зэрэг сэдэвт сургалт, сурталчилгаа ярилцлагыг хийн зөвлөгөө өгч Дархан-Уул аймаг, Мандал сумын өртөөндөх ард иргэдэд сургалт сурталчилгааны 8 төрлийн 350 гаруй гарын авлага материалыг тараалаа.

Аймгийн Эрүүл мэндийн газар, Геронтологийн үндэсний төв, Түнхэл тосгоны эрүүл мэндийн төвийн хамт олон хамтран “Настны эрүүл мэндийн төлөө хамтдаа” уриан дор Түнхэл тосгоны 55-аас дээш насны иргэдийн биеийн байдлыг хянан нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг хийж, зөвлөгөө өгөн, хэвтрийн болон өндөр настануудад гэрээр асаргаа сувилгаа хийх ажлыг зохион байгууллаа.

3.Нийгмийн даатгалын талаар:

Нийгмийн даатгалын сангуудад 10910.7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 11005.1 сая төгрөг хурааж, төлөвлөгөөний биелэлт 100.8 хувьтай байна.

Тайлант сард Тэтгэврийн даатгалын сангаас 14714 тэтгэвэр авагчдад 19120.5 сая төгрөгийн тэтгэвэр, Тэтгэмжийн даатгалын сангаас 3168 даатгуулагчдын хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн амаржсан, оршуулга 834.3 сая төгрөгийг зарцууллаа. Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 323 тэтгэвэр авагчдын 669.8 сая төгрөгийн тэтгэвэр олгон, Ажилгүйдэлийн даатгалын сангаас 254 хүнд 206.1 сая, Эрүүл мэндийн даатгалыг сангаас нийт 9 эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 30928 хүний эмчилгээний зардалд 1149.6 сая төгрөг шилжүүлээ.

39 эмийн сангаар үйлчлүүлэх 7033 иргэний эмийн үнийн хөнгөлөлтөнд 56.5 сая төгрөгийг олголоо .

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хугацааг сунгасантай холбогдуулан орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилгаа хийж, ард, иргэдээс материал хүлээн авах ажлыг үргэлжүүлэн хийж байна.

4. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 404 иргэнд 114.1 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 485 иргэнд 42.1 сая төгрөг, жирэмсэн, хөхүүл нярай 2175 эхэд 691.9 сая төгрөг, алдарт эхийн 1, 2 дугаар зэргийн одонтой 8335 эхэд 1137.9 сая төгрөг, хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээнд 18.8 сая төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 35 иргэнд 59.7 сая төгрөгийн үйлчилгээг үзүүллээ.

5. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:

Тайлант сард ажил идэвхтэй хайгч ажилгүйчүүдийн бүртгэлд 180 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 251 ажлын байранд 206 хүнийг ажилд зуучлан ажилгүйчүүдийн тоо 902 боллоо.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 14 аж ахуй нэгж, иргэний 42 ажлын байр шинээр бий болгох төсөлд 365 сая төгрөгийг олголоо.

“Ажилтай орлоготой Монгол залуу” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Ажлын гараа” төслөөр тус аймгийн 15 оюутан, удирдан чиглүүлэх нэг багшийн бүрэлдэхүүнтэйгээр иргэн Д.Тугбаярынд өвөлжөө барих ажлыг зохион байгуулж байна. Мөн “Сумын залуус” төсөлд 16 сумын 60 оюутан ажиллаж, давхардсан тоогоор 3459 иргэнд Боловсрол, эрүүл мэнд, Англи хэл, бизнесийн чиглэлээр сургалт зохион байгууллаа.

Нийтийг хамарсан ажлаар Баянгол суманд Ногоон байгууламжийн ажлыг зохион байгуулж 14 иргэнийг 10 хоног ажиллуулан 1394400 төгрөгийн цалингийн санхүүжилтийг шилжүүлэн, Орхон суманд 20 иргэнийг 14 хоног үерийн далан барихад ажиллуулан 3384.0 мянган төгрөгийг олголоо.

6. Хүүхэд залуучуудын талаар:

Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 92 жилийн ойн баяр наадмаар Монгол Улсын аварга цол хүртсэн Гунаажавын Эрхэмбаярт хүндэтгэл үзүүлэх “Сэлэнгэ түмний талархлын баяр, наадам”-аар нийт 3 насны 260 гаруй морьд уралдан, хурдан морь унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрх ашгийг хамгаалах, “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хувцас, хэрэгсэлд тавигдах шаардлага MNS:2011” стандартын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж, ослын даатгалд бүрэн хамрууллаа.

Геннисийн номонд бүртгүүлэх 10.0 мянган морьтны жагсаал, 3.0 мянган морьдын уралдаанд тус аймгийн 550 морьтон жагсаж, 200 морьд уралдаж улсын хэмжээнд хамгийн их морьд оролцуулж 3 дугаар байр болон сайн зохион байгуулалттай аймгаар шалгарч, унаач хүүхдийг гэнэтийн ослын даатгалд 100 хувь даатгуулж ажиллалаа.

Тав.Хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар, Хөдөө, аж ахуйн их сургуультай хамтран тайлант сард нийт 10 сумын 40 гаруй аж ахуйн нэгжийн ургацын байдалтай танилцаж, 2013 оны 8 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд ургацын балансаа тогтоолоо.

Тус аймагт 2013 онд нийт 167002 га талбайд тариалалт хийснээс үр тариа 138979 га талбайд тариалж 1127 га мөндөрт, 798 га ган, 246 га-г тэжээлд шилсэн бөгөөд 136558 га хураан авахаас 7443 га талбай сүүн болц, 127944 га талбай аарцан болцын шатанд явагдаж байна.

Аймгийн ургацын урьдчилсан балансаар нийт 163487 га талбайгаас 14.7 цн/га буюу 240218 тн ургац авах төлөвтэй байна. Үүнээс 133216 га талбайгаас 15.7 цн/га буюу 209586 тн улаанбуудай, 1678 га талбайгаас 17.5 цн/га буюу 2880 тн тэжээлийн ургамал, 25282 га талбайгаас 9.2 цн/га буюу 23198 тн рапс, 3991 га талбайгаас 152 цн/га буюу 60664.5 тн төмс, 2285 га талбайгаас 155.1 цн/га буюу 35432 тн хүнсний ногоо хураан авах төлөвтэй байна.

Энэ онд нийт 129984 га талбайд уринш бэлтгэснээс 83891 га-д химийн уринш, 46093 га-д механик уринш бэлтгэж эргэлтийн талбайгаа 96.2 хувьтай ашиглаж байна.

Улаанбаатар хотын 9 зах, дүүргүүдэд, 17 сумын 116 ногоочдын 500 гаруй тн төмс, 644 тн хүнсний ногооны борлуулалтыг хийгээд байна.

2013-2014 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж байна. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 210 тоот тогтоолын дагуу өвсний нөөц бүрдүүлэх зорилгоор нэг хонин толгойд өдөрт 1 кг өвсөөр тооцон нийт малын 30 хувийг нэг хоногт тэжээх өвсний 70 хувиар өвсний нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.

8 дугаар сарын 29-ний байдлаар аймгийн дүнгээр 6520 тн өвс бэлтгэж, хадланд 622 хүн, механикжсан 29, бага оврын трактор 138 ажиллаж байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор, 51 тн мах махан бүтээгдэхүүний 290 дээж, 1100 л сүү, сүүн бүтээгдэхүүний 55 дээж, 800 ширхэг өндөгний дээжинд мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийж гэрчилгээ олголоо.

Зургаа. Газрын харилцаа, Байгаль орчны бодлогын хүрээнд:

1.Газрын харилцааны талаар:

Сүхбаатар сумын иргэдээс Алтанбулаг сумын 3-р баг Цэнхрийн буланд шинээр газар өмчилж авсан иргэдэд өмчилж авсан газрын нэгж талбарын эргэлтийн цэгүүдийг газар бэхлүүлэх мэдэгдлийг гаргаж мэргэжлийн байгууллагад хүргүүллээ.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд заасны дагуу хамтран өмчлөгч хасах хэлцэл байгуулсан 4 иргэний өмчлөх эрхийг хэвээр үлдээж, хамтран өмчлөгчөөс 11 иргэнийг хасч газар өмчлөх эрхийг нээж өглөө.

Аймгийн Засаг даргын 1 удаагийн захирамжаар одоо эзэмшиж буй хашааны газраа өмчилж авсан 8 иргэнд 0.88 га буюу 27.2 сая төгрөгийн үнэ бүхий газрыг нэг удаа үнэ төлбөргүйгээр өмчлүүлэх шийдвэр гаргалаа.

Дархан-Уул, Булган, Орхон, Төв, Өмнөговь аймгууд, Алтанбулаг, Шаамар суманд газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан Сүхбаатар сумын 34 иргэнд тухайн сумаас газар өмчилж аваагүй тодорхойлолт лавлагаагаар үйлчиллээ.

Газар эзэмших, ашиглах эрхээ арилжааны банкинд барьцаалсан тухай Улсын бүртгэлд 24 иргэний 40 нэгж талбар, 3 аж ахуйн нэгжийн 12 нэгж талбарыг бүртгэлээ.

2.Барилга хот байгуулалтын талаар:

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай 48 барилга байгууламжид захиалагчийн хяналтыг хийн ажиллаж байна. Үүнд: Алтанбулаг, Жавхлант суманд баригдсан 75 ортой хүүхдийн цэцэрлэг, Сүхбаатар сумын 3-р

багийн нутаг дэвсгэрт баригдсан Газар хөдлөлийг бүртгэх станцын барилга, тус сумын 5-р багт баригдсан ахуйн үйлчилгээний барилгын ажил бүрэн дуусч улсын комиссоор хүлээн авав.

Түшиг сумын сургуулийн барилгын гадна цэвэр, бохир ус, дотор цэвэр, бохир усны угсралтын ажил, Цагааннуур сумын халуун усны барилгын засвар, Хүн эмнэлгийн барилгын сантехникийн засвар, Ерөө сумын цэцэрлэг, хүн эмнэлгийн барилгын гадна цэвэр бохир ус, дотор цэвэр бохир усны шугамын угсралтын ажил, Дулаанхаан тосгоны 75 хүүхдийн цэцэрлэг, Баруунбүрэн сумын Спорт заал, Баянгол сумын 75 хүүхдийн цэцэрлэг, Мандал сумын 100 хүүхдийн дотуур байр, 560 хүүхдийн сургуулийн барилга, Үнэгт багийн 50 ортой цэцэрлэгийн барилга, Сүхбаатар сумын худалдааны төвийн барилгын ажлуудын явцад хяналт хийж, газар дээр нь зохих шаардлага зөвлөмжүүдийг өглөө.

3.Байгаль орчны талаар:

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, ой судалгаа хөгжлийн төв УТҮГ-аас Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан “Ойн ангийн ажилтнуудыг чадавхижуулах” нь сэдэвт сургалтанд аймгийн байгаль орчны газрын мэргэжилтнүүд болон Хүдэр, Ерөө, Мандал, Баруунбүрэн, Алтанбулаг сумдын ойн ангийн дарга инженерүүд нийт 18 хүн хамрагдлаа.

Байгалт орчин, ногоон хөгжлийн яамны бодлогын хэрэгжилтийг хангах газар тус аймгийн байгаль орчны газар хамтран Алтанбулаг, Түшиг сумдын нутагт Улсын хил дагуу ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор татсан шороон зурвасны ажлын явцтай танилцаж, хяналт шалгалт хийлээ.

Аймгийн Засаг даргын захирамжаар Ерөнхий боловсролын сургуулийн химийн хичээлд ашиглагдахгүй болсон бодисуудын талаар нийт Ерөнхий боловсролын сургуулиудаас судалгаа авч, 2013 оны 9 дүгээр сард устгал хийх бэлтгэл ажлыг хангаж байна.

Тайлант сарын 1, 2, 5, 6, 10, 11, 15, 16, 19, 20,-нд нийт сумдын нутгаар 0.0-87.0 мм, 13, 14-нд нутгийн хойд болон баруун хэсгээр 0.0-13.0 мм бороо орлоо. Ихэнх хугацаанд салхи баруунаас 3-8 м/сек, 15, 16, 19, 20-нд салхи борооны өмнө түр зуур ширүүсч 6-11 м/сек хүрлээ. Шөнөдөө 10-15 градус, өдөртөө 21-26 градус дулаан байлаа. 7, 8, 17-ны өдрүүдэд бага зэрэг сэрүүсч шөнөдөө 7-12 градус, өдөртөө 17-22 градус дулаан байлаа.

4.Тээвэр авто замын талаар:

Орон нутгийн авто зам, замын байгууламжийн нэр, чиглэл, замын эхлэл төгсгөлийн талаар судалгаа авч, бүртгэн мэдээллийн санд баяжилт хийх ажлыг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын захирамжаар Тээвэр авто, замын газар нь Авто тээврийн үндэсний төвийн тус аймаг дахь салбартай хамтран ааої òаої ёёёёі оёїų í үзлэг тооллого, оношлогооний үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, осол авааргүй зорчигч тээвэрлэлтийг явуулах зорилгоор өдөр тутмын хяналт шалгалтыг хийж, Сүхбаатар сумын хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн тээврийн хэрэгслүүдэд стандарт шаардлагын дагуу хаяг, эмблемийг жигдрүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Долоо.Сүм орон нутгийн талаар:

1.Баруунбүрэн сум:

Тус суманд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Гонгорын Бумбаны тахилга хурал номыг 2013 оны 8 дугаар сарын 8-10-ны өдрүүдэд Амарбаясгалант хийдэд 3 өдөр хурж, Баруунбүрэн сумын Засаг даргын Тамгын газар, Сайхан сумын

сум дундын цагдаагийн тасагтай хамтран нийгмийн хэв журмыг сахиулах, хог хаягдал ихээр хаяж байгаль орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэн, нийт 60 тонн хогийг цэвэрлэн зайлуулах ажлыг зохион байгууллаа.

Баруунбүрэн, Сант, Хушаат зэрэг сумдын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, ойн хамтын эзэмшлийн нөхөрлөлүүдэд түлшний болон хэрэглээний мод бэлтгэх стандарт, Ойн тухай хуулийн ухуулга сурталчилгааг хииж, хууль бус үйлдэлтэй тэмцэх, таслан зогсоох, зорилгоор тус сумын Засаг даргын Тамгын газраас эргүүл шалгалтын нийт 13 удаагийн ажил, арга хэмжээг зохион байгууллаа.

Тус сумын эрүүл мэндийн төв нь энэ сард амбулаторын үзлэгээр 62 хүн үзэж осол гэмтэл 2, алсын 10 дуудлага, ойрын дуудлагаар 25 иргэнд үйлчиллээ.

Баруунбүрэн сумын Амарбаясгалан хийд орчмын газар зохион байгуулалт, төлөвлөлтийг хийж зурагжуулан, 14 иргэнд 29000 м/кв газрыг өмчлүүллээ.

2.Баянгол сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газар “Хүлэг морин” уяачдын холбоотой хамтран сумаас төрсөн “Монгол Улсын Алдарт уяач” нарт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, уяачдын баярыг 2013 оны 8 дугаар сарын 4-ний өдөр зохион байгууллаа.

Мерси Кор олон улсын байгууллага, Монголын нутгийн удирдлагын холбоо тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Сумын эдийн засгийн хөгжлийн цогцолбор төлөвлөгөө боловсруулах арга зүйн сургалт”-ыг 2013 оны 8 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтанд үндэсний зөвлөх багш, аймгийн зөвлөх багш 2, Баянгол, Хушаат, Цагааннуур, Сант, Жавхлант, Шаамар сумдын 6 чиглүүлэгч багш, төр төсвийн байгууллагын дарга, бизнесийн эрхлэгч иргэдийн төлөөлөл, иргэдийг хамруулан зохион байгууллаа.

Сумын Засаг даргын 2013 оны А/140 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж ургацын урьдчилсан баланс тогтоох зорилгоор аж ахуй нэгж, иргэдийн төлөөллийг оролцуулан ажлын хэсэг байгуулагдаж тус сумын хэмжээнд тариалсан үр тариа, тэжээлийн ургамал, тосны ургамал төмс, хүнсний ногооны ургацыг урьдчилсан байдлаар тогтоолоо. Тус ажлын дүнгээс үзэхэд ургацын хувьд жигд сайн, үр тариа 15 цн/га, тэжээлийн ургамал 10 цн/га, тосны ургамал 9,8 цн/га, төмс 110 цн/га, хүнсний ногоо 134цн/га ургац хураахаар тогтоогдож, 10406 тн буудай, 95 тн тэжээлийн ургамал, 1056.5 тн рапс, 2694 тн төмс, 1565.54 тн хүнсний ногоо хурааж авахаар төлөвлөж байна.

3.Зүүнбүрэн сум:

Сумын Засаг даргын 2013 оны А/110 тоот захирамжаар архи согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчлэх цагийг хязгаарлаж, хариуцлагыг сайжруулах зорилгоор архи согтууруулах ундаа худалдан борлуулах цагийг 20 цаг, архи согтууруулах ундаагаар үйлчлэх баар, зоогийн газрын үйлчилгээг 22 цагаар тогтоож, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Тайлант сард үргэлжлэн орсон борооны улмаас усны түвшин нэмэгдэж байгаатай холбогдуулан голын ай сав дагуух газраар намаржиж буй малчин өрхүүдийг тус сумын гамшгаас хамгаалах комиссоос айл өрхүүдэд албан мэдэгдэл хүргүүлж, нүүлгэх ажлыг зохион байгуулж байна.

Мал аж ахуйн 2013-2014 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд байгалийн гамшиг, зуднаас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын нутаг дэвсгэрт өвөлжих малыг хонин толгойд шилжүүлж тооцон, орон нутгийн нөөц бүрдүүлж бэлтгэсэн өвсний хэмжээ нөөцлөх цэгийн уртраг өргөрөгийн байршлыг тогтоох ажлыг зохион байгуулж байна.

4.Мандал:

Тайлант сард сумын Àì üæððààãäüì æð ç° âë° è õóðàëäààн òúðäýáýð 70, í° õõ° èò ì° í° ðí° òúðäýì æ 7, ìðí° òàçèéí ò° í° ð° è° èò 4, àòì àà áí èí í° ò° æèèéí áýððø ýýèòýé èðäýí èé ò° í° ð° è° èò 45, æðýì ñýí í ýðàè ýðèéí òúðäýì æ 54, àèääðò ýðèéí î äí î æéí 4 í èéò 184 èðäýí èé ì àðàðèàèýг òçèýýí àâ÷ òýéýèòлэ.

Ýì í ýèæéí àæè÷äüí áàýðü äóðàì “Тохилог орчинг хамтдаа бүтээцгээ” сэдэвт 2 ñàðüí äýí çì òèíí áàéæòéæ ø èí ý áçòýýè÷ àæèóóäü ä ñàí àà÷èáí òèéæ ýì ÷, àæè÷èä, çèè÷èççèýã÷äýä ýýèòýé î ð÷èí áçðäççèýð çì òèèã òààèí àæèèèаж байна.

Тус сумын иргэдэд номын сангийн болон соёлын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор сумын Засаг даргын Тамгын газар, Түнхэл тосгоны соёлын төвтэй хамтран алслагдсан баг, тосгоны иргэдэд үйлчлэх “Номтой аялал” нүүдлийн номын сангийн нээлтийг хийн, иргэдэд явуулын үйлчилгээгээр үйлчиллээ.

2013 оны 8 дугаар сарын 5-7-ны өдрүүдэд “Ноён тур” амралтын төвд “Боломж” Хүүхдийн оролцооны удирдах Зөвлөл 10-р чуулганыг зохион байгууллаа.

Зүүнхараа сангийн аж ахуйн 90 жилийн ойг угтан улсын уран хагалгааны аварга Борхүү агсаны нэрэмжит уран хагалгааны сумын аварга шалгаруулах тэмцээнийг, Хэрх тосгоны ахмад харваач Дамба-очир агсны нэрэмжит шагайн харваан нээлттэй тэмцээнийг зохион байгууллаа.

5.Орхон:

Тус сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран зам засвар, замын тэмдэг тэмдэглэгээ, “Үерийн далан” нийтийг хамарсан ажлуудыг тус тус зохион байгуулж 610 метр замыг засварлан 630 метр газрыг ухаж, цементлэн үерийн далан байгуулан, зам засварын ажилд нийт 6600.0 мянган төгрөгийг зарцуулж давхардсан тоогоор тус сумын 40 ажилгүй иргэнийг түр ажлын байраар хангаж ажиллалаа.

Тус сумын Бэлэндалай багийн нутаг дэвсгэр болох 42-р зөрлөгийн гарам батлагдсан замгүй учир үерийн усанд идэгдэж, эвдэрч элэгдсэн, намгархаг хөрстэй учир машин техник явахад хүндрэлтэй болж, иргэдийн санал санаачлагаар 2013 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 1.2 км газрыг 60.0 сая төгрөгийн өртөгөөр засварлаж эхлээд байна.

Сумын Засаг даргын 2013 оны ургацын урьдчилсан тогтоолт явуулах тухай А/115 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж, сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ургац тогтоох ажлыг зохион байгуулж, үр тариа 16,8 цн, рапс 8,6 цн, төмс 127 цн, хүнсний ногоо 100 цн-ээр тус тус тогтоогдлоо.

2013 оны бэлчээрийн хортон мэрэгч устгалтын ажлыг зохион байгуулж тус сумын Бэлэндалай багийн Өнгөтийн арын 3000 га бэлчээрийг хамрууллаа.

6.Орхонтуул сум:

Тус соí üí идäýäèéí Ò° è° è° ä÷èéí Хурлын Õýðäççèýã÷èéí 2013 îí ü 2 дугаад ñàðüí 20-í èé ° äðèéí õóðàëäààì ààð áàòàèñàí “Ахмад í àñòàì ä õóñèàì æ ò° í° ð° è° èò ççççèýð журам”-ü ä õýðýæççèýð çì òèèã î ð õóñ ñòì üí áàéæèèéí ççýñäýéýì ò äàçàðòò байрлах “Ар булаг”-ийн амралтанд тайлант ñàðä 17 өндөр настанг амрааж ñóàèèуулах ажлыг зохион байгууллаа.

Тайлант сард “Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд мал ээмэгжүүлэх ажлыг çðäýèæççèýí хийж 28 өрхийн 780 толгой үхэр хамрагдлаа. Í í ü ýóí èé 8 ñàðüí áàéèèààð áí ä ì àèын 77,9 хувь õýýèòççèýð î ðж, үүнээс èí äý 75, äç 2845, çì ýý 4030 áçä 6950 òí èã é áí ä ì àè õýýèòççèýã î ðлоо.

Тус суманд “Í ðíí í íóæèéí ò° æèèéí ñàí”-ààð Ààýí òí äò 2-ð áàäò 5.0 ñàý ò° äò æөр “Ахмадын áàéðí ü засвар”, 5.0 ñàý ò° äò æөр “Ногоон байгууламж”, 10.0 ñàý ò° äò æөр ñòì üí Ýðççè ì ýí àèéí төвийн “Вакумцонх” ò° ñèççèèèè èðäýäèéí áçèäçä

àâ- õýõýæ¿¿ëýüä áàéí à. Õí í ã ð-í âí í 3-ð áààð áàæéí Çàñàã ààðää, áàæéí áàää ýí ÷ééí áàéðí ù çàñààð, òí í í ã ð° ð° ð° ð° í æ Õàëóóí òñ ñàóí ð° ñë¿¿ä õýõýæææð° ä° ð° æéí èðäýä ýí í ýéýæéí àí òàí ø àòí ù ¿éë-èèäýüä òóðääí ø óóðòàé áààð í° òó° è á¿ðäý¿, í èéðèéí òàëóóí òñ, ñàóí ààð òí äèí í è ¿éë-èè¿¿ëýõээр áоллоо. Øàð-Õñ 1-ð áàã Ðàø ààí ò òí ñã í ä àðóéí ¿éë-èèäýýí èé áàðèèää, í í ã í í áàéæóóèàí æ òàø áàæóóèàèð ð° ñë¿¿äééí áàæè ýõèýüä áàéí à.

7.Сайхан:

“Архидан согтуурахтай тэмцэх ажлыг журамлах тухай тус сумын Засаг даргын А/192 тоот захирамж гарч, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллага, худалдаа үйлчилгээний газрууд согтууруулах ундааг 7 хоногийн 3 дахь өдөр худалдахыг хориглон, бусад өдрийн 20 цаг хүртэл худалдаалахаар шийдвэрлэж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Тайлант сард тус суманд 19 хүүхэд шинээр мэндэлж, ургийн овог, овог нэр, нэр өөрчлөлтийн бүртгэл 3 хийдэн, гэрлэлтээ бүртгүүлсэн 7, Нас барсан 4, шилжин явсан 83, шилжин ирсэн 41 бүртгэл тус тус хийгдсэн байна.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, төр төсвийн байгууллагын ажилчид албан хаагчдад Эрүүл мэнддээ анхаарах, зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх болон суугаа ажилтай хүмүүс дасгал хөдөлгөөн хэрхэн хийж хэвших талаар сургалт зохион байгууллаа.

Сайхан сумын малчид, мал бүхий иргэдээс ноосны урамшуулалд 149 малчин өрхийн 36363 кг ноосны материалыг хүлээн авч аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газарт хүргүүлэх ажлыг зохион байгууллаа.

8.Сүхбаатар сум:

Тайлант сард сум хөгжүүлэх сангийн зээл олгох ажлын хүрээнд тус сумын нийт 34 иргэний 139180.0 мянган төгрөгийн зээлийг олголоо.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Хаш чулуу” нөхөн сэргээгдэх төвд 14 ахмад настан 16 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгууллаа.

“éèäáýð хөдөө аж ахуйн яамны захиалагаар “Ногоон эдийн засаг” ТББ-ààñ үйлдвүð ð° ä° ð° àæ àðóéí òàèààð áàðèè òàèæáóé áí äèí äíí õýõýææèð, èðäýäýä ¿¿¿èèæ буй ¿éë-èèäýýí èé ÷áí àð, ò¿ðòýýí æéí òàèààðð õýõýæýä-èéí ñóààèääáá тус ñóí ùí 130 èðäýí ýýñ Õ° ä° ð° àæ àðóéí ÷èäýýè, Ì àè àæ àðóéí ÷èäýýè, ð°í ð°í ¿éèäáýðèýèéí чиглэлүүдээр тус тус áàèàà.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Ì í í ã è ì àè ¿í äýñí èé ð° ð° èá° ð, Ì í í ã è òéñíí Çàñæéí ääçðíí 221 ä¿äýð òí äèí í èí ð “Хонины ноос, тэмээний ноос áýèðäýæ ¿í äýñí èé ¿éèäáýðò òóø áàñáí ì àè-èí, ì àè á¿ðèé ýõäýüäýä òàí èèòóóèæ äýýðòè òðàí ø óóèàè ì èã ò тухай журам”-ùã ñóí ùí í èéð ì àè á¿ðèé èðäýäýä òàí èèòóóèæ äýýðòè òðàí ø óóèàèä õýõýýí òàí ðàääàò, íííñíí õýðõýí áýèðäýð, òàáí à ° ð° òàèààð ääðíí áàèàää ì àðàðèàèààð òàí äæàæèèàà.

9.Алтанбулаг сум:

Тайлант сард тус суманд нийт 13 хүүхэд төрснөөс 7 эрэгтэй, 8 эмэгтэй хүүхэд төрж, 2 гэр бүл шинээр гэрлэлтээ бүртгүүлж, 34 хүн шилжин явж, 26 хүн шилжиж ирлээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Ахмадын толгойн тохижилт, зам засвар”-ын ажил, угтан авах үдэн гаргах “Алтанбулаг хаалга”-ыг хийж хүлээн авч ашиглалтанд орлоо.

2012-2013 оны мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор байгалийн хадлан бэлтгэх хүсэлт гаргасан 27 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 242 га газар хадлан бэлтгэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Тус сумын иргэдэд галын түлээ бэлтгэх эрхийн бичиг 1226 м³-ыг олгож орон нутгийн орлогод байгалийн нөөц ашигласны төлбөр 2665.6 мянган төгрөг, тэмдэгтийн хураамж 305.5 мянган төгрөг, хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичиг 334 м³-ыг олгож 1039.5 мянган төгрөг, тэмдэгтийн хураамж 13500 төгрөгийн орлого орууллаа.

10.Хүдэр сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Хүдэр сумын Засаг даргын 2012-2013 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг ном болгох эхийг бэлтгэн, 500 ширхэгийг хэвлүүлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргэх ажлыг зохион байгууллаа.

Тайлант сард тус сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас 3-р улиралд зохион байгуулсан ажил, цаг үеийн ажлын мэдээллийн талаар иргэдтэй уулзалт ярилцлага хийн, иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авлаа.

Ажил идэвхтэй хайгч ажилгүй иргэдийг ажлын байраар хангах зорилгоор тус сумын Засаг даргын Тамгын газраас Хүдэр суманд үйл ажиллагаа явуулж буй Төмөрлөгийн уурхайн үйлдвэртэй хамтран эхний ээлжинд 25 иргэнийг баяжуулах үйлдвэрт ажиллуулахаар болж 15 иргэнийг тус аж ахуйн нэгжийн тусламжтайгаар сургалтанд хамруулж ажлын байртай болгохоор шийдвэрлэлээ.

Хачигт энцефалит өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг Төмөрлөгийн уурхайн ажилчдад хийх ажлыг зохион байгууллаа.

Орон нутгийн татварын орлого 136015,5 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс, гүйцэтгэл 162015,0 мянган төгрөг орж 119 хувийн биелэлттэй байна. Гадуур патент төлөгч иргэдийн орлогыг бэлэн мөнгөний тасалбараар хураан авч, татварын өртөй аж ахуйн нэгжүүдэд мэдэгдэл өгч, шүүхэд шилжүүлэх ажлыг зохион байгуулж, байгаль орчны албатай хамтран модны гоожингийн дутуу төлөлт 8600,0 мян төгрөгийг орууллаа.

11.Цагааннуур сум:

Түшээт хан аймгийн Эрдэнэ вангийн хошууны алдарт хурдан хүлэг “Товхон ханы Буган халиун”-ы нэрэмжит их нас, соёолон, дааган насны морьдын уралдааныг 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Цагааннуур суманд зохион байгууллаа. Уралдаанд их нас 69, Соёолон нас 38, дааган насны 57 хурдан хүлгүүд шандас хурдаа сорьж, түрүү морьдод Товхонханы хурдан хүлэг “Буган халиун”-ны хүрэл баримлыг дурсгал болгон хадгалууллаа.

Тус сумын Оргих 1-р баг болон Тийрэг 3-р багийн малчдын өдөрлөгийг 8 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд хийж, Цагааннуур сумын Засаг дарга, Засаг даргын орлогч болон түүний Тамгын газрын холбогдох мэргэжилтэнүүд, соёлын төв, эрүүл мэнд, боловсролын байгууллагуудын ажилчид, иргэдэд цаг үеийн мэдээ мэдээлэл өгч, урлаг, спортын арга хэмжээг зохион байгууллаа.

2013 оны 8 дугаар сарын 1-ээс 2013 оны 11 дүгээр сарын 1-ний хооронд Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо борлуулах хүсэлтэй байгаа тус сумын 11 иргэн, 1 аж ахуйн нэгжийг бүртгэн нийт 542 тн төмс, 91,9 тн хүнсний ногооны борлуулалт хийх тухай холбогдох материалыг бүрдүүлэн Үйлдвэр хөдөө аж ахуйн яаманд хүргүүллээ.

12.Шаамар сум:

Тайлант сард хөдөлмөр эрхлэлтийн бүртгэлд бүртгэлтэй ажилгүй иргэдээс 3 иргэнийг ажилд зуучлан байнгын ажлын байраар хангалаа.

Шаамар суманд Дулаанхаан тосгоны ахмадын “Аялгуу” хамтлагын шог хошин болон харилцаа дууны сэдэвчилсэн тоглолтыг зохион байгуулж нийт 200 гаруй үзэгчид үзэж сонирхлоо.

Газрын тухай хуулийн дагуу газар эзэмших эрхээ шилжүүлэх хүсэлт гаргасан 4 иргэний хүсэлтээр сумын Засаг даргын захирамжаар 1.9 га газрын газар эзэмших

эрхийг шилжүүлж улсын бүртгэлд бүртгэлээ. Шинэчилсэн кадастрын зургаар газар эзэмших эрхээ баталгаажуулахаар 2 иргэн хүсэлт гаргаж сумын Засаг Даргын захирамжаар дахин баталгаажуулах ажлыг хийлээ.

Монгол Улсын иргэн бүрт газар өмчлүүлэх хуулийн хүрээнд хуучин эзэмшиж байсан газраа өмчлөх хүсэлт гаргасан 4 иргэнд 0.57 га газрыг тус сумын Засаг даргын захирамжаар 2583.0 мянган төгрөгийн үнэ бүхий газрыг үнэ төлбөргүйгээр өмчлүүлээ. Урьд жилүүдэд хамтран газар өмчилсөн 3 иргэний хамтран өмчлөгч салгуулах гэрээг үндэслэн 8 иргэнийг сумын Засаг даргын захирамжаар хасч цаашид газар өмчлөх эрхийг нээлээ.

13.Түшиг сум:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Архигүй орчин” хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулан, архи согтууруулах ундааг зарж борлуулах цагийн хуваарийг улирлын нөхцөл байдалтай холбогдуулан өөрчилж хавар, зун, намрын улиралд 19:00 цаг, өвлийн улиралд 17:00 цагаас хойш худалдаалахыг хориглож, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

“Ажилтай, орлоготой Монголчууд” хөтөлбөрийн хүрээнд тус сумын Засаг даргын Тамгын газар оюутан сурагчдын “4 бэрх” багийн гишүүдтэй хамтран “Хариу нэхээгүй тус” аяны ажлаар сумын ар нуга 2-р багийн иргэн С.Хатанбаатарын ар гэрт байгалийн гамшиг тохиолдох үед нурсан байшинг нөхөн сэргээн засварлаж туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгууллаа.

Түшиг сумын залуучуудын идэвх санаачлагаар анх удаа тус суманд “Залуучуудын зөвлөл”-ийг шинээр үүсгэн байгууллаа.

Сум хөгжүүлэх сангийн орон тооны бус зөвлөл хуралдаж нийт 170 сая төгрөгийн 26 төслийг хэлэлцэж, 13 төслийг сонгон шалгаруулж, 10 ажлын байр шинээр бий боллоо.

Тус суманд тохиолдсон гамшгийн улмаас төр захиргааны байгууллага, ард иргэдэд үлэмж хэмжээний хохирол учирч, сэргээн босголтын ажлыг шат дараатайгаар хийж байна.

Найм.Бусад ажлын талаар:

Онцгой байдлын газар:

Аймгийн Онцгой байдлын газраас “Зочид буудал”, “Аялал жуулчлалын бааз”, “Уул уурхайн байгууллага”-уудад гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх сэдэвт нэгдсэн арга хэмжээний удирдамж, график төлөвлөгөөний дагуу урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг зохион байгууллаа. Хяналт шалгалтыг “Гамшгаас хамгаалах тухай”, “Галын аюулгүй байдлын тухай”, “Барилга байгууламжийн галын аюулгүй байдал” /БНБД 21-01-02/, “Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм” /БНБД 21-02-02/, “Олон нийтийн барилга” /БНБД 31-03-03/, “Цахилгаан техникийн ажил” /БНБД 3.05.06.90/ зэрэг стандарт, техникийн нормативуудыг удирдлага болгон, 320 ц^о д-÷-ëë, äòàäãäë ëëðççëñí ýýñ 65 ц^о д-÷-ëë, äòàäãëüâ тухайн үед арилгуулж, äóñàä ц^о д-÷-ëëëä арилгуулахаар зäàäãë äèäëççëüö àèááí ø ààðäëäãä 63, мэдэгдэл 24-ийг үйлдэж холбогдох эрх бүхий албан тушаалтнуудад өглөө.

Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Аврах, гал унтраах 36 дугаар ангиас Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт Орхон гол, Сэлэнгэ мөрний эргээр өдөр бүр 8-12 хүний бүрэлдэхүүнтэй эргүүл шалгалтыг зохион байгуулж, 3325 иргэнд ухуулга сурталчилгаа хийж, “Гол мөрний усанд осолдохоос сэргийлье”, “Үер усны аюулаас урьдчилан сэргийлье” сэдвээр сэрэмжлүүлэг бэлтгэн тараалаа.

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Аврах тусгай анги, Дархан-Уул, Булган, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар, хэлтэстэй хамтарсан “Урсгал усны дадлага”-ыг зохион байгууллаа.

2013 оны 8 дугаар сард Аврах, гал унтраах ангиуд нийт 5 удаагийн объектын гал түймрийн дуудлагаар байлдааны тархалт хийж, нийт 1 тасгийн хүчээр 4 гал түймрийг 9 тонн ус, 93.4 литр шатахуун зарцуулан унтрааж, гал түймрийн аюулаас аж ахуй нэгж, байгууллагын 54 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалан 2 гал түймрийн хэрэг зөрчлийг цагдаагийн байгууллагатай хамтран шалган акт тогтоосон.

Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:

Тус аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс, Говь-Алтай аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтэстэй туршлага солилцох, уулзалт ярилцлага зохион байгуулж, төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэхэд тулгамдаж буй асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцох ажлыг зохион байгууллаа.

4 сумын 4 аж ахуйн нэгжийн 4 нэрийн 7 хүнсний бүтээгдэхүүнийг тохирлын баталгаажуулалтад хамрууллаа. Сүхбаатар суманд шинээр үйл ажиллагаа эхэлж буй “Баян ээж Сэлэнгэ” ХХК-ий үйлдвэрлэж буй “Family” кимчины сав баглаа болон хаяг шошгыг Монгол Улсын “Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгололтонд тавих шаардлага MNS CAC 1:2007” стандартын шаардлагад нийцүүлэн гаргуулж, бүтээгдэхүүнийг сорилт шинжилгээнд хамруулан, зохих дүгнэлтийг гаргалаа.

“Алтан тариа” ХХК-ий Сэлэнгэ аймаг дахь салбар нь БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод Буудайн хивэг экспортолж эхэлсэн бөгөөд одоогоор 6 удаагийн тээвэрлэлтэд тохирлын гэрчилгээ олгоод байна.

Түшиг, Зүүнбүрэн, Шаамар, Алтанбулаг сумдын айл өрх, аж ахуй нэгж, албан байгууллагын төлбөр тооцоонд ашиглагдаж буй 1 фазын 1125, 3 фазын 6 тоолуурт баталгаажуулалт хийсэн.

Мэргэжлийн хяналтын газар:

Шинэ Зеландын Фонтерра үйлдвэрийн шар сүүний уургийн хатаасан бэлдмэлийг ашиглан БНХАУ, Канад, Вьетнам, Тайланд, АНУ, Саудын араб улсуудад үйлдвэрлэсэн хүүхдийн тэжээл болон хуурай сүүг лабораторийн шинжилгээнд хамруулж, холбогдох шинжилгээний дүн, улсын байцаагчийн дүгнэлтийг гаргах хүртэл худалдан борлуулахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмжийг худалдаа үйлчилгээний байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас эхний 8 сарын байдлаар нийт 1135 объектийг хяналт шалгалтанд хамруулж, 1874 зөрчил илрүүлэн, 54,1 сая төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулж шийдвэрлээд байна.

Мэргэжлийн хяналтын газрын дэргэдэх итгэмжлэгдсэн лаборатори нь эхний 8 сарын байдлаар нийт 291 аж ахуй нэгжийн 45 нэр төрлийн 980 дээжинд 4824 үзүүлэлтээр хими, нян судлал, ургамал хорио цээрийн шинжилгээг хийхэд 17 нэрийн 179 дээж 262 үзүүлэлтээр эерэг гарлаа. 179 дээж нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй байгаа нь нийт дээжийн 18.26 хувийг эзэлж байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР